

БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН

2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Багануур дүүргийн Шүүхийн Тамгын газар нь ШЕЗ-өөс 2016 онд дэвшүүлсэн бодлого, зорилтын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж, хууль тогтоомж эрх зүйн актын хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хангаж, хамгаалах, шүүхийн захиргааны удирдлагыг оновчтой хэрэгжүүлэн, хүний нөөц, төсөв санхүү, дэд бүтцийн удирдлагыг тасралтгүй хэрэгжүүлж, шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангаснаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Нэг. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАЖ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг ханган, хамгаалж ажилласнаар шүүхүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдлаа. Шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн Олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэгтэй хамтран зохион байгуулж байна.

Тайлангийн хугацаанд хуралдсан 1883 оролцогчтой эрүүгийн 121, иргэний 287, захиргааны зөрчлийн 2 нийт 410 хуралдааны аюулгүй байдлыг хангаж оролцогчдын биед үзлэг шалгалт хийж зөрчилгүй ажиллав.

Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх аливаа оролдлогоос урьдчилан сэргийлж, 61 иргэн, хэргийн оролцогчийн шүүгчтэй уулзах уулзалтыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулав. Шүүгч нарын албан өрөөнд шүүгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс дуудлагын хонх байрлууллаа.

Шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд /Улаанбаатар хотоос 3 шүүгч ажилд явдаг/ хот хоорондын нийтийн тээвэрт зорчигч тээвэрлэдэг Юнайтед БРА хоршооны 46, Тээвэр ачлал компаний 20 тээврийн хэрэгслийн судалгааг гаргуулан авч холбогдох санамжийг хүргүүлсэн. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэгт шүүгч нарын аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан шүүгчдийн орон байр болон шүүхийн байр хооронд явганаар зорчих чиглэл, орчны фото судалгааг хийж авах үүрэг өгч гүйцэтгүүлсэн. Шүүхийн байрны инженерийн шугам сүлжээний зураг, судалгааг хамтран гаргаж албажуулсан.

Шүүгч нарыг оройн цагаар ажлын байранд сууж ажиллах, хуралдаан оройтсон үед ар гэрт нь хүргэх ажил үүргийн хуваарийг боловсруулж шүүгч, цагдаагийн алба хаагч нарт танилцуулж хэрэгжүүлснээр 8 удаа шүүгчдийг ар гэрт нь хүргэсэн байна.

Тайлангийн хугацаанд шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудал гараагүй байна. Шүүгчид нөлөөлөх, нөлөөлгийн мэдүүлэг хөтлөх нөхцөлтэй холбогдуулан гаргасан ШЕЗ-ийн тогтоолын тодорхой хэсгээр дүүргийн нутгийн захиргааны удирдах ажилтнууд болон цагдаагийн байгууллагад сургалт хийж, гарын авлага тараасан.

Шүүхийн хэвийн ажиллах эдийн засаг, хүний нөөц, техник зохион байгуулалтын нөхцөл бололцоог тухай бүрт ханган ажиллалаа. Тайлангийн жилд шүүгч, ажилчдын цалин, томилолтонд 559.069. сая төгрөгийн хоол, унааны зардалд 24.544.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Шүүхийн захиргааны 26 ажилтан шүүх, шүүгчийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллажээ.

Шүүгч тус бүр өөрийн албан өрөөнд тус тусдаа ажил үүрэг гүйцэтгэж байгаа ба гарын дор зайлшгүй шаардагдах тавилга хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан .

Хоёр.ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус газар нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Шүүхийн тухай багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам, Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын албан томилолт, чөлөө олголт, автомашин ашиглалтыг журмын дагуу хэрэгжүүлэн ажиллалаа. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд 2 удаа өөрчлөлт оруулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн хүний нөөц, хэргийн хөдөлгөөн, сургалт, сурталчилгаа, төсөв санхүү, харилцаа холбоо, техник хангамж, холбогдох бусад асуудлыг тухай бүрт мэргэжлийн удирдлагаар хангаж үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хэвийн хадгаллаа. 2016 оны 01-р сарын 24-ний өдөр төрийн захиргааны 15, төрийн үйлчилгээний 10 албан хаагчтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулж гэрээний биелэлтэнд сар бүр явцын хяналт хийж хагас жилээр дүгнэж үнэлэлт дүгнэлт өгсөн.

ШЕЗ-ын гишүүн Д.Эрдэнэчулуунаар ахлуулсан Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тайланг танилцуулах, Шүүхийн тамгын газрын үйл ажилгаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэг 2016 оны 02 дугаар сарын 28-29-ны өдрүүдэд Шүүхийн тамгын газарт хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар дурдсан зөрчилгүй сайн шалгагдсан.

Тамгын газраас гарч буй эрх зүйн актын хууль зүйн үндэслэлд онцлон анхаарч ажилласны дээр шүүгч, ажиллагсдын нийгмийн болон бусад харилцааг хууль зүйн дагуу зохицуулахад түлхүү анхаарлаа.

Эвлэрүүлэн зуучлалын талаар

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хэрэглэгдэх 13 төрлийн баримт, тэмдэглэл, бүртгэлийн 5 дэвтэр журмын дагуу хөтлөгдөж байна.

Тус газарт орон тооны 1 эвлэрүүлэн зуучлагч ажиллаж байна. Жил ирэх тусам эвлэрүүлэн зуучлах ажиллагааны ачаалал өсч байгааг харгалзан 2016 оны 02 дугаар сараас байгууллагын хөдөлмөрийн дотоод зохион байгуулалтад өөрчлөлт оруулж эвлэрүүлэн зуучлагчийн туслахын орон тоог шинээр гарган ажиллав.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд шинээр 245 өргөдөл хүлээн авсан бөгөөд урьд оны үлдэгдэл 16 өргөдөл нийт 261 өргөдөл хүлээн авсан байна. Үүнээс 213 өргөдөлд эвлэрлийн гэрээ байгуулж шүүгчийн захирамжаар баталгаажуулж, 26 өргөдөл хүлээн авахаас татгалзаж, 12 өргөдөл буцааж 10 өргөдлийн үлдэгдэлтэй байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд ирүүлсэн өргөдлийн 239 нь иргэний эрх зүйн маргаан, 4 нь гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан, 2 нь хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан байна. Тайлангийн хугацаанд Эвлэрүүлэн зуучлагчид 751 иргэн хандсан байна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар гарын авлага, хэвлэмэл хуудсыг тогтмол хэвлэж иргэдэд тарааж, эвлэрүүлэн зуучлахаар маргаанаа шийдвэрлүүлсэн иргэдээс санал асуулга авч санал хүсэлтийг нь үйл ажиллагааны тусган ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 11-12-р ангийн сурагчдын дунд Эвлэрүүлэн зуучлалын талаар сургалт зохион байгуулж эссэ бичлэгийн уралдаан зарлаж дүгнэсэн.

Багануур дүүргийн шүүхийн Тамгын газраас эрхлэн гаргадаг “Шүүхийн мэдээ” сонинд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мэдээллийг нийтлүүлсэн байна.

Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Хаан ,Хас банк, Голомт, Капитал,Төрийн банкны салбаруудад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар сурталчилж сургалт зохион байгуулсан.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаар

2016 онд Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах иргэдийн нэрсийн жагсаалтыг батлуулах ажлын хүрээнд Багануур дүүргийн 25 наснаас дээш 14484

иргэний нэрийг санд оруулахаар хүргүүлснээс 159 иргэдийн төлөөлөгчийн нэрс батлагдаж Иргэний хэргийн 19 шүүх хуралд 19 , эрүүгийн хэргийн 12 шүүх хуралд 14, нийт 31 хуралд 33 иргэдийн төлөөлөгч оролцсон байна. Иргэдийн төлөөлөгчөөс хамааралтайгаар шүүх хуралдаан хойшилсон тохиолдол гараагүй ба тэдгээрт 220996 төгрөгийн урамшуулал олгосон байна. Иргэдийн төлөөлөгчийн мэдээг хугацаанд нь ШЕЗ-д хүргүүлсэн.

Багануур дүүргийн Иргэн, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Иргэдийн төлөөлөгчийн програмыг нэгтгэж долоо хоног бүр Тамгын газрын даргын тушаалаар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн дэд жагсаалтыг баталж байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдааны товыг ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, хэргийн материал, эрх үүргийг танилцуулсан талаар баримт үйлдэж, шүүх хуралдаан болохоос 30 минутын өмнө шүүх хуралдааны нийтлэг журам, дэгийн талаар шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн мэдээлэл өгч, шүүх хуралдааны өмнө тангараг өргүүлэн ажиллаж байна.

2016 онд Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцохоор нэр дэвшсэн иргэд болон Багануур дүүргийн 1-5 дугаар хорооны Иргэдийн нийтийн хуралдаан дээр Шүүхийн иргэдийн төлөөлөгч, нөлөөллийн мэдүүлэг сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтанд оролцогчдын сонирхсон асуултанд зохих хариулт өгч мэдээллээр хангалаа. Нийт 3 удаагийн сургалтанд сонгогдсон 90 орчим төлөөлөгч хамрагдав.

ШЕЗ-өөс бэлтгэж ирүүлсэн гарын авлага материал, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар талаарх танилцуулга зэргийн сургалтад оролцсон иргэдийн төлөөлөгч бүрт гардуулсан.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай ойлголтыг иргэдэд өгөх үүднээс “Сүлжээ-3”, “BBS” телевизээр Нээлттэй нийгэм форум, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран бэлтгэн гаргасан Шүүхийн иргэдийн төлөөлөгч гэсэн видео бичлэгийг сард 2 удаа, мөн өөрийн шүүхийн вэб сайт, фэйсбүүк хаягаар цацаж байна

Шүүхийн шуудангийн найдвартай ажиллагааг хангасан байдал

Багануур дүүргийн Шүүхийн тамгын газар, “Монгол шуудан” ТӨКХ-ийн Багануур шуудангийн салбар, хороодын хэсгийн ахлагч нарын хамтарсан уулзалт ярилцлагыг зохион байгуулж гибрид шуудангийн үйлчилгээг сурталчилж шүүхийн үйлчилгээг хөнгөвчилсөн, дэвшилттэй ажил үйлчилгээ болох талаар ойлголт өгч,

шуудан хүргэгч, хороодын хэсгийн ахлагч нар харилцан ойлголцож, цаашид харилцан хамтарч ажиллахаар тохиролцсоны үр дүнд гибрид шуудангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудангийн үйл ажиллагаа бүрэн найдвартай хангагдсан.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 10 дугаартай тогтоолоор баталсан хавтас хэрэг илгээх журмын дагуу тус газрын шүүхүүдээс богцоор давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхэд нийт 61 хэрэг явуулснаас 52 хэргийг хүлээн авсан байна. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журмын дагуу харуулын цагдаа шуудан холбооны газраас богцоор хавтаст хэрэг хүлээж авах, хүргэж өгөх үеийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд үндсэн 19 төрлийн бүртгэл, Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхэд үндсэн 27 төрлийн нийт 36 төрлийн бүртгэл, Тамгын газарт 6 төрлийн бүртгэл зааврын дагуу хөтлөгдөн хянагдаж холбогдох мэдээлэл судалгаа бүртгэлийн дагуу нэгтгэгдэж байна.

Тамгын газрын даргын тушаал 66 гарснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 43, хүний нөөцтэй холбоотой тушаал 23 байна. Тайлангийн хугацаанд Тамгын газарт 151, Эрүүгийн шүүхэд 58, Иргэний шүүхэд 121, нийт 330 албан бичиг ирж, 391 албан бичиг гадагш явсан ба хугацаатай албан бичгийн хариуг хуульд заасан хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Тус шүүхийн архивт тооллогоор 2002 оноос хойших байнга хадгалагдах иргэний хэрэг 232 нэгж, түр хадгалах иргэний хэрэг 8526 нэгж, шүүхийн байнга хадгалах эрхийн акт 55731 нэгж, түр хадгалах эрхийн акт 960 нэгж, Тамгын газрын байнга хадгалах 75 нэгж, түр хадгалагдах 136 нэгж, 2016 оны эрүүгийн 65 хэрэг, захиргааны зөрчлийн материал 105 нэгж, хянан магадлангийн 114 нэгж, иргэний 454, иргэний буцаасан, татан авсан материал 14 нийт 66412 нэгж материал хадгалагдаж байна.

2015 оны Эрүүгийн 126 хавтаст хэргийг УЕП-ын дэргэдэх ЭХ-ийн төв архивт 2016 оны 03 сарын 22-ны өдөр тушаалаа. Үүнээс: Түр хадгалах эрүүгийн хэрэг 126 хавтас, шийтгэх тогтоолын өнгөн хувь 4 хавтас, 2015 оны эрүүгийн үндсэн бүртгэл 20 хавтас тус тус тушаагдав.

2015 оны хянан магадлангийн 399 хавтас материалыг НПГ-ын дэргэдэх Эрүүгийн хэргийн салбар архивт 2015 оны 03 сарын 21-нд тушаасан бөгөөд хянан магадлангийн захирамжийн эх хувь 2 хавтсыг тушаасан байна.

Иргэн байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтээр 51 удаа архивын лавлагаа гаргаж өгч архивын тооллогыг 2016 оны 01 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд явуулж дүн мэдээг хүргүүлсэн.

Эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах чиглэлээр

Эрүүгийн 14 хэрэгт хураагдсан 112 эд мөрийн баримтыг хүлээн авч 12 хэргийн 44 эд мөрийн баримтыг устгасан байна. Үлдэгдэл 2 хэргийн 68 эд мөрийн баримтыг зохих журмын дагуу хадгалж байна. Тамгын газрын даргын 2016 оны 05 дугаартай тушаалаар Эд мөрийн баримт устгах, барьцааны мөнгө, үнэ бүхий зүйл хүлээн авах, хадгалах ажилтнаар Ерөнхий шүүгчийн туслах Б.Мөнх-Учралыг томилж, Эд мөрийн баримт устгах орон тооны бус комиссыг шинэчлэн байгуулсан.

Хэргийн хөдөлгөөний чиглэлээр

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2007 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандарт”, 2016 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал” болон Шүүхэд албан хэрэг хөтлөх журам, Хэргийн индексийн журам, Эд мөрийн баримт болон барьцааны мөнгө, үнэ бүхий зүйлийг шийдвэрлэх журам, МУ-ын Шүүхийн нууцын журам, хавтаст хэрэг илгээх, хүлээн авах журам, Шүүхийн архивын ажиллах журам зэргийг мөрдүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллаж байна. Хэргийн хөдөлгөөнд тавих хяналтыг шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн болон Ерөнхий шүүгчдийн туслахууд хариуцаж төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг явуулж гаргасан алдаа зөрчлийг цаг тухайд нь арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр хяналт шалгалтыг сайжруулж ажилласан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллын судалгааг хагас, бүтэн жилээр гарган хэргийн ачааллыг тэнцвэржүүлэх, буруулах талаар судлан ажиллаж байна. Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь 4 шүүгчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд жилд дунджаар нэг шүүгч өргөдөл, гомдол, захиргааны зөрчил, хянан магадлан, цагдан хорих хүсэлт, эрүүгийн хэрэг зэрэг 118 материалыг хянан шийдвэрлэж байна. Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх нь 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд нэг шүүгч жилд дунджаар эвлэрлийн гэрээг баталгаажуулах, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлт 150, иргэний 110 хэргийг хянан шийдвэрлэж байна. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2016 оны 63 дугаар тогтоолоор Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Төмөрбаатарын Ганчимэгийг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 6 сарын хугацаагаар томилолтоор ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Шүүх хуралдааны товыг долоо хоног бүрийн 4 дэх өдөр гаргаж цаг тухай бүрт нь www.shuukh.mn болон www.baganuurshuukh.mn сайтад байршуулж хэвшсэн.

www.shuukh.mn www.baganuurshuukh.mn, сайтад иргэний шүүх хуралдааны тов-327, тойм-316, шийдвэр 495 эрүүгийн шүүх хуралдааны тов-170, тойм- 168, шийтгэх тогтоол 83 -ыг байршуулсан байна

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 10 дугаартай тогтоолоор баталсан хавтас хэрэг илгээх журмын дагуу богцоор давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхэд эрүүгийн 22 хэрэг богцоор явснаас 21 хэрэг ирсэн, захиргааны зөрчлийн 2 материал авснаас 1 материал ирсэн, Иргэний 37 хэрэг явснаас 31 хэрэг ирсэн байна. Оны эхний хагас жилд зарим тохиолдолд богцгүй болох асуудал гарсан учраас шүүх тус бүр дээр 4 богц нэмэлтээр захиалж авсан. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журмын дагуу харуулын цагдаа нараар шуудан холбооны газраас богцоор хавтаст хэрэг хүлээж авах, хүргэж өгөх үеийн аюулгүй байдлыг хангуулж ажилласан байна.

Иргэний хэргийн шүүн таслах ажлын талаар

Тайлангийн хугацаанд 2015 оны үлдэгдэл 79, шинээр 601, нийт 680 нэхэмжлэл хүлээн аваад байгаагаас 77 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 9 хэргийг буцааж, 4 хэргийг шилжүүлж 512 хэрэг хянан шийдвэрлэсэн, үлдэгдэл 52 хэргээс 7 хэргийг түдгэлзүүлсэн, 2 хэргийг хойшлуулсан байна. Эвлэрүүлэн зуучлагчаас ирүүлсэн 225 материалыг баталгаажуулсан байна.

Шүүхийн тогтоол 23, шийдвэр 512, шүүгчийн захирамж 1919, шийтгэвэр 1 тус тус гарч бүртгэлийн програмд гүйцэтгэх хуудас 342, давж заалдах болон хяналтын 37 гомдол, албадан гүйцэтгэх 326 хүсэлт бүртгэгдсэн байна.

Иргэний 74 хэргийн шүүх хуралдаан холбогдох шалтгааны улмаас хойшлогдсон нь нийт товлогдсон шүүх хуралдааны **23.4** хувийг эзэлж байна.

Эрүүгийн хэргийн шүүн таслах ажлын талаар

Тайлангийн хугацаанд 2015 оны үлдэгдэл 5 яллагдагчид холбогдох 4 хэрэг, шинээр 103 яллагдагчид холбогдох 87 хэрэг хүлээн авч 4 яллагдагчид холбогдох 3 хэргийг мөрдөн байцаалтад буцааж, 95 шүүгдэгчид холбогдох 80 хэргийг хянан шийдвэрлэж 9 шүүгдэгчид холбогдох 8 хэргийн үлдэгдэлтэй байна.

Давж заалдах болон хяналтын шатаар тус шүүхийн 22 хэрэг хянагдсанаас 10 буюу 45.4 хувь нь хэвээр, 11 хэрэг буюу 50 хувь нь хүчингүй болж үлдэгдэл хэрэг 1 байна. 23 эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон нь нийт товлогдсон шүүх хуралдааны 20 хувийг эзэлж байна.

Захиргааны зөрчлийн 143 материал хүлээн авснаас 27 материалыг нотлох баримтын шаардлага хангаагүй үндэслэлээр арга хэмжээ авахаас татгалзан буцааж, 116 хүнд холбогдох 116 зөрчлийг хянан шийдвэрлэсний 41 хүнийг торгож, 75 хүнийг баривчилсан байна.

Сэжигтнийг хойшлуулшгүй ажиллагаагаар баривчлуулах тогтоол шүүхэд 30 ирснээс 27 сэжигтнийг баривчилж, 3 сэжигтнийг татгалзсан. Сэжигтнийг цагдан хорих 27, яллагдагчаар үргэлжлүүлэн 17 цагдан хорих санал хүлээн авч шийдвэрлэжээ. Цагдан хорих арга хэмжээг өөрчилж бусдын батлан даалтад өгсөн 22, бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорьсон 1, цагдан хорих хугацааг сунгасан 12, сэжигтнийг цагдан хорихоос татгалзсан 6, яллагдагчаар цагдан хорихоос татгалзсан 2, өөр газар шилжүүлэн цагдан хорьсон 6 захирамж тус тус гаргасан байна. Нийт 44 сэжигтэн, яллагдагчид холбогдох 123 захирамж гарсан байна.

ШШГЕГ-ын харьяа Хорих-0427 ангиас 116 санал хүлээн авч 36 ялтныг тэнсэн суллах, 79 ялтныг дэглэм бууруулах, 1 ялтныг дэглэмийг дээшлүүлж шийдвэр гаргажээ. 5 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд үлдэгдэлгүй шийдвэрлэсэн байна.

Програм хангамж, мэдээллийн технологийн талаар:

Байгууллагын албан хэрэгцээнд 38 компьютер, 1 хувилагч, 14 хэвлэгч, 19 хяналтын камер болон бусад тоног төхөөрөмж, дотоод болон интернэтийн сүлжээний хэвийн, тасралтгүй ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангаж техник хангамжийн бүртгэлийг хөтлөн ажиллаж байна.

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан онлайн хурлуудыг явуулах бэлтгэл ажлыг хангаснаар 2016 онд иргэний 1 шүүх хуралдаан, Эрүүгийн 2 шүүх хуралдаан, ШЕЗ-өөс зохион байгуулсан нийт 13 сургалт, 6 шүүгчдийн зөвлөгөөнд онлайн ашиглалаа.

Програм хангамж, тоног төхөөрөмжийн 46 гэмтэл, 23 сүлжээний доголдлыг бүрэн арилгаж ажилласан. Үүнээс үзвэл сард дунджаар 2-3 гэмтэл, сүлжээний доголдол гарч байна.

baganuurshuukh.mn сайтын загварын шинэчлэлийг хийж, цаг үеийн ажлын мэдээ мэдээллийг тухай бүрт www.baganuurshuukh.mn сайтад байршуулж төрийн үйл ажиллагааг иргэдэд сурталчиллаа. Сайтад нийт 42 мэдээ мэдээлэл байршуулсан байна.

“Иргэн-2014” нэгдсэн програм болон “Judge2005” програмын шинэчлэлт болон өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд хуралдсан 410 шүүх хуралдааны дүрс бичлэгийг хард дискэнд хуулж, зохих журмын дагуу архивлав.

Нэхэмжлэлийн загвар, хохирогчийн эрх үүрэг, нэхэмжлэгчийн эрх үүрэг гэх мэт мэдээллүүдийг иргэд татаж авахад зориулан shuukh-help.pro –ийг хийж ашиглаж байна.

Шүүхийн мэдээлэл технологийн үйл ажиллагааг гадны нөлөөнөөс хамгаалах зорилгоор WI-FI router ашиглахаас татгалзсаны дээр IP address search суулган сүлжээнд гаднаас ямар нэгэн компьютер нэвтэрч буй эсэхийг шалгаж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мэдээллийг тодорхой хугацаанд файлаар архивлах зорилгоор server компьютерт байгаа нийт файлыг хард дискэнд буулган цахим архив үүсгэн ажиллаж байна.

Шүүхийн VPN сүлжээний ачааллыг бууруулах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын интернэтийн зохистой хэрэглээг бий болгох, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Facebook, Twitter, Youtube сайтуудыг ажлын өдрүүдэд 09.00 цагаас 17.00 цагийн хооронд нэгдсэн журмаар хаасан.

Тайлан мэдээний талаар:

Тайлангийн хугацаад ШЕЗ болон холбогдох бусад газраас ирүүлсэн 151 албан бичгээс хариутай 78 албан бичгийг хугацаанд нь хүргүүлсэн байна. Эрүүгийн шүүхээс 9 төрлийн, Иргэний шүүхээс 11 төрлийн, Тамгын газраас 45 төрлийн судалгаа, мэдээ тайлан, санал асуулгыг хуулийн хугацаанд гаргаж ШЕЗ болон холбогдох газарт, үйл ажиллагааны явцад бусад газруудаас ирүүлсэн 8 төрлийн судалгаа мэдээ тайланг тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2008 оны 4 дүгээр сарын 25-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүхийн статистикийн тайлан, мэдээлэл гаргах журам”, Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 01/95 тоот тушаалын 1-12 дугаар хавсралт маягтын дагуу дараах мэдээнүүдийг гаргаж 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдөр **Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнд хүргүүлсэн. Мөн заасан хугацаанд Шүүн таслах ажиллагааны 1, 3 дугаар улирлын мэдээг хүргүүлсэн.**

Үүнд:

1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн мэдээ ШС-1 /Шүүхээр оногдуулсан ялын товчооны хамт/;
2. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн мэдээ ШС-2 /Шүүхээс төрийн санд оруулсан тэмдэгтийн хураамжийн мэдээний хамт/;
3. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн мэдээ ШС-3 /Шүүхээс төрийн санд оруулсан тэмдэгтийн хураамжийн мэдээний хамт/;
4. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн мэдээ ШС-4;
5. Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний мэдээ ШС-5;
6. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн сулласан, ялаас чөлөөлсөн мэдээ ШС-6;

Нэмэлт мэдээ

- Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шийдвэрлэсэн мэдээ;
- Зохион байгуулалттай гэмт хэргийг шийдвэрлэсэн мэдээ;
- Төрийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэсэн мэдээ;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон, медалиар шагнуулсан хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэсэн мэдээ;
- Иргэдийн төлөөлөгчдийн оролцооны мэдээ;
- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны мэдээ;

ГУРАВ.ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

Төлөвлөлт, судалгаа, өөрчлөлтийн талаар

Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 5, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 4, нийт 9 шүүгч, Тамгын газарт төрийн захиргааны 17, үйлчилгээний 10, нийт 36 ажилтан, албан хаагчийн орон тоо батлагдсанаас тайлангийн хугацаанд батлагдсан орон тоогоор бүрэн ажиллалаа.

Монгол улсын Шүүхийн хүний нөөцийн системд шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэдээллийг цаг тухай бүр нь шинэчлэн, програмын баяжилтыг хийж байна

Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажилтнуудтай 2016 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэлд сар, улирлаар хяналт тавьж хагас жилээр үнэлэлт дүгнэлт өглөө.

Байгууллагад хүний нөөцтэй холбоотой 4 төрлийн нэгдсэн судалгаа хөтлөгдөж байна.

Тайлангийн хугацаанд төрийн үйлчилгээний 1 албан хаагч чөлөөлөгдөж, 1 үйлчилгээний албан хаагчийн албан тушаалыг өөрчилж, 1 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй байна.

Төрийн албан хаагчдын баримт бичгийн бүрдлийн талаар

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг дагуу Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын хувийн хэрэг, холбогдох материалд цаг тухай бүр баяжилт хийж хөдөлгөөнийг бүртгэж байна.

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан, 1 шүүгчид их хэмжээний өөрчлөлт орсон даруйд өөрчлөлт хийлгэж ШЕЗ-д хүргүүллээ. УИХ-ын ТББХ-ны тогтоолын дагуу 2015 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий 13 албан тушаалтны ХОМ-ийг гаргуулан авлаа. Шинээр томилогдсон 1 албан тушаалтнаар нийтийн албаны ашиг сонирхлын мэдүүлэг гаргуулан АТГ-т хүргүүлж дүгнэлт гаргууллаа.

Мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр

ШЕЗ-өөс болон УДШ, сургалт судалгааны бусад байгууллагаас зохион байгуулсан 13 удаагийн сургалтанд шүүгч, шүүхийн захиргааны 19 ажилтан хамрагдсан байна. Байгууллагын дотоод сургалтыг 2016-2017 оны төлөвлөгөөний дагуу Монгол хэлний зөв бичгийн дүрмийн сургалтыг 2016 оны 04 дүгээр сараас эхлэн зохион байгуулж нийт 20 цагийн сургалтад шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд хамрагдлаа. Эрүүл мэнд, харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилгоор цагийн сургалтуудыг зохион байгууллаа.

Шүүхийн захиргааны 3 албан хаагч мэргэжил, боловсролоо дээшлүүлэхээр Их засаг Их сургуулийн магистрийн ангид суралцаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журмаар жил бүр улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад хамт олноор амжилттай оролцсон.

2016-2017 оны хичээлийн жилийн биеийн тамирын арга хэмжээний төлөвлөгөө хөтөлбөрүүд батлагдан Гүн Галуутай цогцолбор сургуультай гэрээ байгуулан 7 хоног бүрийн Пүрэв гарагт спорт заланд тоглож шүүгч, албан хаагчдыг 5 багт хувааж Сагсан бөмбөг, гар бөмбөг, явган аялал, ширээний теннис, дартс, боулингийн тэмцээн зохион байгуулж багуудыг нийлбэр оноогоор дүнгэж шагналаа.

Шүүгч, ажилтны нийгмийн баталгааг хангах талаар

Батлагдсан төсөв төсвийн хуваарийн хүрээнд шүүгч, ажилтны эрүүл мэнд, нийгмийн даатгалд 26.578,1 сая, унаа хоолны зардалд 24.544.4 сая төгрөг зарцууллаа.

Албан хаагчдын 84 хувь нь өөрийн орон байр, гэрт, бусад нь түрээсийн орон байранд амьдарч байна. Эдгээр нь шүүхийн захиргааны ажилтнууд байна.

Шүүгч, шүүхийн захиргаа, үйлчилгээний ажилтнуудыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах ажлууд хийгдлээ.

- Шүүгч нарыг “Люкс мед” эмнэлэгт тархины MRI-д харуулж эрүүл мэндийн үзлэгт хамруулсан
- Бие бялдрын сорил авах ажиллагаанд нийт ажилтнуудыг хамруулж, Sport.gov.mn сайтад бүртгүүлсэн.
- Улаанбурханы вакцинд байгууллагын 18-30 насны залуучууд хамрагдсан.
- Байгууллагад эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх эм, эмнэлэгийн хэрэгсэлтэй боллоо.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын ажиллагсдын хүүхдүүдэд 39 гарын бэлэг гардууллаа.
- Байгууллагын харьяалалтай 3 өндөр настанд ахмадын баярыг тохиолдуулан нийт 150.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж үзүүллээ.
- Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Оюунбат “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн ” одонгоор,
- Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Нарантуяа “Алтан гадас” одонгоор
- Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч П.Цэцэгдулам “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр
- Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Ганчимэг “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан байна.
- Шүүгч ажилчдын дунд “Миний ээж” сэдвээр Монгол бичгээр эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав.
- “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэв.

- Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны 95 жилийн ойн баярын хүрээнд Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан Гар бөмбөг, Ширээний теннис, Боулинг, Буудлагын тэмцээнд амжилттай оролцлоо.
- “Цэвэр агаар-Эрч хүч” явган аялал зохион байгууллаа
- Байгууллагын албан хаагчдын дунд Спортын 5 төрөлт цуврал тэмцээн зохион байгуулж дүгнэлээ.
- Дорнод, Дархан, Сэлэнгэ аймгийн Шүүхийн туршлага судлав.
- Түүхт Халхын гол, Буйр нуур, Сайхны хөтөл, Аглаг бүтээлийн хийдээр аялал зохион байгуулав.
- Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс Нийслэл дэх Шүүхүүдийн дунд хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд Алтан медаль, шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдлаа
- УДШ-ийн 90 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан спортын наадмын эрэгтэй гар бөмбөгийн төрөлд хүрэл медаль хүртлээ.

Шүүхийн захиргааны ажилтны харилцаа, ёс зүйн талаар

ШЕЗ өөс баталсан “Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хорооны ажиллах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төрийн захиргааны албан хаагчийн болон Шүүхийн ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, хяналт тавьж мөрдүүлэх чиг үүргийн хүрээнд Тамгын газрын дотоод журамд 2 заалтаар нэмэлт өөрчлөлт оруулсан.

Байгууллагын Ёс зүйн хорооны гишүүдийн орон гарсантай холбогдон тус хороог шинэчлэн зохион байгуулж, хамт олны саналаар Ёс зүйн хорооны даргаар Д.Анхбаяр, гишүүдэд П.Нансалмаа, Б.Хэрлэнчимэг нар томилогдон ажиллаж байна.

2016 оны 5 дугаар сард “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам” сэдвээр цуврал сургалт зохион байгуулсан.

Шүүхийн захиргааны ажилчдаас “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Шүүхийн ажилтны ёс зүйн дүрэм”, “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын журам” сэдвийн хүрээнд 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр сорилын шалгалт авлаа. Шалгалтын зорилго нь Шүүхийн захиргааны ажилчдын ажлын хариуцлага, харилцаа хандлага, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдлээ.

Тайлангийн хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчиж, өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй 2, байгууллагын дотоод журам зөрчсөн 2, ёс зүйн зөрчил гаргасан 1, нийт 5 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Дөрөв: ШҮҮХИЙН ТӨСӨВ САНХҮҮ ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР
Шүүхийн төсөв санхүү, дэд бүтцийн талаар

2016 оны төсвийн төлөвлөлтийг 2014 оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж 2015 оны 06 дугаар сард ШЕЗ-д хүргүүлсэн. 2016 онд батлагдсан төсвийг хууль, тогтоомж, төсвийн хуваарийн дагуу захиран зарцуулж, улирлын тайлан баланс, холбогдох судалгааг хугацаанд нь гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

- 2016 оны тодотгосон төсвөөр тус шүүхэд 775.378.5 ₮ батлагдсан болно. Үүнээс 2016 оны эхний 11 сард 710.777.7 ₮ батлагдсанаас 670.607,4 төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс:
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 582.630,9 ₮ батлагдаж 546.339,0 -ны гүйцэтгэлтэй,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 64.089,6 ₮ батлагдаж 60.215,1 ₮-ны гүйцэтгэлтэй,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 18.391,4 ₮ санхүүжилт авч 18.391,4 төгрөгний гүйцэтгэлтэй ,
- Хангамж бараа материалын зардалд 26.200,6 ₮ санхүүжилт авч 26.200,6 төгрөгний гүйцэтгэлтэй
- Нормативт зардалд 400,0 ₮ санхүүжилт авч 400,0 төгрөгний гүйцэтгэлтэй
- Эд хогшил урсгал засварын зардалд 8.707,8₮ санхүүжилт авч 8.644,2 төгрөгний гүйцэтгэлтэй
- Томилотт зочны зардалд 1.051,1₮ санхүүжилт авч 983,0 төгрөгний гүйцэтгэлтэй
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2.819,2₮ санхүүжилт авч 2.398,2 төгрөгний гүйцэтгэлтэй
- Урсгал үйл ажиллагаанаас 157.000 төгрөгний орлого орсон байна. Нийт 40.170,2 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.

Байгууллагын орон тооны бус эд хөрөнгийн комиссыг байгуулж хадгалалт, ашиглалт, хамгаалалтыг хариуцуулан ажиллаж байна. Үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогыг хугацаанд нь хийж балансад тусгавал зохих хөрөнгийн бүртгэлжүүлээ. Мөн дөрвөн жилд нэг удаа сангийн яамнаас үндсэн хөрөнгийн тооллого хийгдэж тооллогоор зөрчлийн акт тавигдаагүй болно. Дансаар 111.800

мянган төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн авто тээврийн хэрэгсэл, 168.891,8 мянган төгрөгийн үнэ бүхий 84 нэр төрлийн тоног төхөөрөмж, 102 нэр төрлийн 105.545,3 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Шүүхийн байрны түрээсийн, ашиглалтын болон холбоо, дулаан, цахилгаан, цэвэр бохир ус, автогражын халаалтын гэрээг холбогдох газруудтай байгуулж хугацаанд нь дүгнэж, төлбөр тооцоог хийж өглөг, авлагагүй ажиллав.

2015 оны Төрийн өмчийн хорооны тогтоолоор 2016 оны эхний хагас жилд 3.996,0 мянган төгрөгний тоног төхөөрөмж, ШЕЗ-өөс 7551,6 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 741,6 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил нийлүүлснийг балансад бүртгэж авсан байна.

Тус дүүргийн татварын хэлтсээс 1-р улирлын цалингийн санд хяналт шалгалт хийсэн шалгалтаар зөрчил гараагүй болно. Монгол улсын Үндэсний аудитын харъяа Нийслэлийн аудитын газраас 2016 оны 3-р улирлын байдлаар явцын хяналт шалгалт хийгдэж санхүүгийн зөрчил дутагдалгүй ажилласныг тогтоосон.

Тав.ШҮҮХИЙН ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

Орон нутгийн Сүлжээ-3, BBS телевиз, Багануурын амьдрал, Багануур ньос сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулан цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр өгч мэдээлүүлж байна.

Шүүхийн шинэтгэлийн бодлогын талаар болоод шүүхүүд, Тамгын газраас зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар орон нутгийн Сүлжээ-3, BBS ТВ-үүдээр давхардсан тоогоор 41 удаагийн мэдээ мэдээлэл хүргэлээ. Багануур ньос сонинд 22 удаа мэдээ нийтлүүсэн байна.

www.shuukh.mn www.baganuurshuukh.mn, сайтад иргэний шүүх хуралдааны тов-327, тойм-316, шийдвэр 495 эрүүгийн шүүх хуралдааны тов-170, тойм- 168, шийтгэх тогтоол 83 -ыг байршуулсан байна.

www.judcouncil.mn www.baganuurshuukh.mn, www.baganuurnews.mn, сайтад нийт 41 мэдээ мэдээллийг байршуулсан байна.

Нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт бичих талаар зөвлөгөө, нэхэмжлэлийн шаардлага, улсын тэмдэгтийн хураамжийн тухай, шүүхэд иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаар нийт 2557 иргэнд холбогдох лавлагаа, мэдээлэл өглөө.

Анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, хэлбэр, агуулга, загвар гэх мэт мэдээлэл агуулсан 10 гаруй гарын авлага, Шүүхийн багц хуулиудын сурталчилгааны материалуудыг олшруулан эрүү, иргэний хэргийн шүүхийн байранд байршуулаад байна.

Шүүхийн улирал тутмын мэдээлэл болох “ШҮҮХИЙН МЭДЭЭ” сонины 3 дугаарыг 3000 ширхэг хэвлэн байгууллага аж, ахуйн нэгж иргэдэд түгээн шүүхийн ил тод нээлттэй байдлыг ханган сурталчиллаа.

- ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад Эрх зүйн ойлголт сэдвээр сургалт зохион байгуулав
- Байгууллага аж ахуйн нэгжүүдийн дунд зохиогдсон “Ханьтайгаа хамтдаа” гэр бүлийн тэмцээнд оролцож түрүүлэв.
- Бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт оролцлоо
- Төгсөх ангийн сурагчдын дунд “Эрх зүйч мэргэжлийг сонгох болсон нь?” эссэ бичлэгийн уралдаан зарлаж дүгнэлээ.
- Монголын бүх ард түмний спортын наадмын хүрээнд зохион байгуулагдсан Багануур дүүргийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд оролцож дэд байр эзэлж мөнгөн медаль гардлаа
- Монголын бүх ард түмний спортын наадмын хүрээнд зохион байгуулагдсан Багануур дүүргийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний 4-р байрт шалгарав.
- Нэн ядуу өрхийн хүүхэд багачуудад туслах “Сайн үйлсийн аян” өрнүүлэв“Шүүхэд баярлалаа” сэдвээр 3 удаа ярилцлага авч орон нутгийн сонин сайтад нийтлэв.
- Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч П.Туяа дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажилчдад Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ сэдвээр сургалт зохион байгуулсан.
- Багануур дүүргийн төр захиргаа, байгууллагуудын удирдлагуудад 2016 оны 11 сарын байдлаар Иргэн, Эрүүгийн хэргийн шүүхээс хянан шийдвэрлэсэн хэргийн талаарх статистик мэдээлэл хийлээ.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН БАГАНУУР ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА: Б.ЭРДЭНЭБАЯР